



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 347

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.3.4, 6.4.2, 6.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Сайншанд дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 27,736,017.00 (хорин долоон сая долоон зуун гучин зургаан мянга арван долоон) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, "Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан хөрөнгийг эргэлтийн хөрөнгөөр ашиглах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007758

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн
22 дугаар тогтоолын хавсралт



Гаалийн ерөнхий газрын харьяа Сайншандын Гаалийн газрын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг сэлбэгийн зориулалтаар "Булган-А33А"
ТӨХК-д шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Тоо шир хэг	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)
1	Ландкрузейр 100 маркийн, 81-83 ДГО улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар- JTECJ06JI055076 10	2002/2002	1	27,736,017.00	27,736,017.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				27,736,017.00 (хорин долоон сая долоон зуун гучин зургаан мянга арван долоон)